

Монгол хэлэн дэх “гүн”-ий зүйрлэлийг сэтгэц хэл шинжлэлийн туршилтын аргаар судалсан нь

Авирмэдийн Цог-Очир 

*Монгол Улсын боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D), зөвлөх профессор, Улаанбаатар, Монгол Улс*

Отгонбаярын Анхилуун 

*Монгол Улсын боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Монгол хэлний тэнхимийн докторант*

Хүлээн авсан - Received:
2025- 11-14

Засварласан - Revised:
2025-12-25

Хэвлэгдсэн - Published:
2025-12-31

tsogochir@msue.edu.mn
ORCID: [0009-0008-0038-4370](https://orcid.org/0009-0008-0038-4370)

ankhiluun@msue.edu.mn
ORCID: [0009-0001-9359-9774](https://orcid.org/0009-0001-9359-9774)



© 2025, Author(s)

Хураангуй: Уг судалгаанд хэмжээ, хэмжигдэхүүн илэрхийлдэг “гүн” болон “гүехэн” хэмээх тэмдэг нэрсийг сэтгэц хэл шинжлэлийн “утгын уялдаа холбоосын туршилт”, болон “утгын ялгамжийг тодорхойлох туршилт”-ын аргуудаар судалж үзэв. Судалгаанд 18-22 насны 100-157 оролцогчийг хамруулав. Өдөөгч үг “гүн”-тэй холбоос үүсгэсэн үгс нийт 1129 (давтагдаагүй тоогоор 266), оролцогч бүр дунджаар 8.5 холбоо үг бичсэн бол өдөөгч үг “гүехэн”-тэй холбоос үүсгэсэн үгс нийт 652 (давтагдаагүй тоогоор 209), оролцогч бүр дунджаар 7.2 холбоо үг бичсэн байв. Давтамж болон дараалалд тулгуурлан өдөөгч үг тус бүртэй хамгийн хүчтэй холбоос үүсгэсэн 20 холбоо үгийг салган авч, +2-оос -2 хүртэлх таван шатлалаар утгын ялгамжийг үнэлүүлэв (+2 нь 100% шууд утгыг, -2 нь 100% зүйрлэлийн утгыг илэрхийлнэ).

Монгол хэлний тайлбар болон зүйлчилсэн толь бичгүүдийн тайлбартай харьцуулахад өдөөгч үг “гүн” нь шууд утга буюу сурвалж хүрээнээсээ цааш оюун санаа, танин мэдэхүйн хүрээ, сэтгэл хөдлөлийн хүрээ, үл мэдэгдэх, нууцын хүрээ, ухамсар мэдрэлийн хүрээ гэсэн дөрвөн утгын хүрээ рүү өргөссөн бол, өдөөгч үг “гүехэн” нь зөвхөн оюун санаа, танин мэдэхүйн хүрээ, сэтгэл хөдлөлийн хүрээ рүү өргөссөн болох нь ажиглагдав. Зүйрлэл ойлгох туршилтын үр дүнд “Ухаан/бодол бол далай”, “Хайр/сэтгэл бол далай”, “Хар өнгө бол далай”, “Зүүд нойр бол далай” гэсэн концептуал зүйрлэлүүд үүссэнийг ажиглаж, концептуал зүйрлэлийн онол болон биед суурилсан танин мэдэх үйлийн онолтой холбон тайлбарлахыг оролдов.

Түлхүүр үг: Танин мэдэхүйн хэл шинжлэл, утгын холбоосын туршилт, утгын ялгамжийг тодорхойлох туршилт, зүйрлэл ойлгох туршилт, концептуал метафор

Оршил

Монгол хэл шинжлэлд тэмдэг нэрийг бүтэц, байр, үүрэг, хэлбэрийн талаас нь судалсан боловч орчин үеийн, хүн төвт хэл шинжлэлийн онол, арга зүйгээр хийсэн судалгаанууд төдийлөн элбэг бус байна. Энэ талаар судлаач Ж.Р.Тэйлор “Тэмдэг нэр нь өгүүлбэр зүй болон утга зүйн судалгаанд орхигдсон ай бөгөөд танин мэдэхүйн бүтцэд гүйцэтгэх үүрэг нь сайн ойлгогдоогүй хэвээр байна” (Cognitive grammar, 2002, хууд. 171) хэмээн дүгнэжээ. Иймд уг өгүүлэлд “гүн”, “гүехэн” хэмээх тэмдэг нэрсийн утгын өргөсөл, тэдгээрээр үүсэх зүйрлэл, түүний утгуудыг сэтгэц хэл шинжлэлийн туршилтын гол аргууд болох утгын холбоосын туршилт /Word-association experiment, Ассоциативный эксперимент/, утгын ялгамжийг тодорхойлох туршилт /Semantic differential experiment, Эксперимент

семантического дифференциала/, зүйрлэл ойлгох туршилт /Metaphor-comprehension experiment, Методика исследования понимания метафоры/-уудаар шинжлэн тогтоож, тайлбарлахыг зорив.

Зүйрлэлийг ихэнх хүн яруу найргийн уран сэтгэмж, риторик хэрэгсэл, зөвхөн хэлний үзэгдэл (сэтгэхүй, үйлдэлтэй холбоо хамааралгүй) гэж ойлгодог учраас зүйрлэхгүйгээр төгс харилцаж чадна гэж боддог. Гэтэл эсрэгээрээ, зүйрлэл нь зөвхөн хэлээр бус, сэтгэхүй болон үйлдлээр дамжин өдөр тутмын амьдралд өргөн тархсан байдаг. Бидний бодож сэтгэх, үйлдэх арга нь үндсэндээ зүйрлэлийн шинж чанартай байдаг (Metaphors we live by (2nd ed.), 2003, хууд. 4) хэмээн судлаач Лакофф, Жонсон нар дурджээ. Иймээс зүйрлэлийн судалгаа нь зөвхөн хэл шинжлэлийн асуудал бус, харин хүний сэтгэлгээний суурь зохион байгуулалтыг шинжлэн тогтоох оролдлого болдгоороо орчин үеийн, хүн төвт хийгээд салбар хоорондын судалгааг чухалчлах болсон шинжлэх ухааны хандлагад нийцэж буй юм.

Зүйрлэл дундаас “гүн”-ий зүйрлэлийг сонгон судлахын онцлогийг судлаач Ж.К.Фойл “A Phenomenology of Depth. Psychoanalytic Dialogues” хэмээх өгүүлэлдээ “Нэгдүгээрт, “гүн” бол ухамсарт бус шинжтэй холбоотой анхны зүйрлэлүүдийн нэг юм. Энэ талаар “...ухамсартай байх эсэх нь гүний сэтгэл судлалын харанхуй дахь ганц гэрэлт цамхаг буюу бидний эцсийн зогсоол юм” (Freud, 1923, p. 18) хэмээн үзжээ. Хоёрдугаарт, “гүн” нь хүн төрөлхтний туршлагын “орон-цаг-бие” хэмээх үндсэн ангилалд багтах зүйрлэл тул өөр өөр соёл, цаг үеүдэд ч тогтвортой оршдог. Эдгээр зүйрлэл нь хүн төрөлхтний амьдралын хэв маягт үндэслэн тухайн цаг үед тохирсон, шинэ утгын давхаргыг үүсгэдэг тул тогтмол шинэчлэгдэж, хэрэглэгдсээр байдаг” (Foehl, 2014, хууд. 290) хэмээн дүгнэсэн буй.

Танин мэдэхүйн хэл шинжлэлд зүйрлэлийн тухай онолын тайлбар олон буй боловч зүйрлэлийг бодит цаг, тухайн агшин /real-time/-д хэрхэн боловсруулж, илэрхийлж, ойлгож буйг харуулах туршилт нотолгоо шаардлагатай мэт. Ийм тохиолдолд дээр дурдсан сэтгэц хэл шинжлэлийн туршилтын аргуудыг ашиглах нь хэл зүйн ойлголтыг тархи хэрхэн боловсруулж буйг судлах боломжийг бүрдүүлж өгнө (Gibbs, 2006) (Glucksberg, 2001). Эдгээр арга нь онолд тулгуурласан судалгаанаас цаашлан, зүйрлэлийг хүний оюун санаанд өрнөдөг танин мэдэхүйн үйл явц хэлбэрээр шинжлэх боломж олгож буй юм.

Түүнчлэн танин мэдэхүйн хэл шинжлэлийн онолын ойлголтыг сэтгэц хэл шинжлэлийн туршилтын аргаар судлах нь өнөөгийн монгол хэлний судалгаанд ач холбогдолтой байж болох юм. Учир нь англи хэл төдийгүй өргөн хүрээнд судалсан бусад хэлнийхтэй адил нийтээр ашиглах боломжтой, томоохон корпусууд манайд ховрын дээр аль жишээ нь зүйрлэл болох, аль нь биш болохыг тогтоосон туршилт нотолгоо, жишээ баримт үгүй байна. Иймд “гүн”, “гүехэн” хэмээх тэмдэг нэрсээр үүсэж буй холбоо үгсийн аль нь зүйрлэл, аль нь биш болохыг утгын холбоосын, утгын ялгамжийн болон зүйрлэл ойлгох туршилтын аргаар тогтоох нь шинжлэх ухаанч хийгээд үнэн бодит үр дүн гаргах магадтай хэмээн үзэж байна. Энэ талаар судлаач М.Ж.Тракслер “Сэтгэц хэл шинжлэлийн туршилтуудыг хэл шинжлэлийн онол, арга зүйтэй хослуулснаар хэлийг боловсруулах үйл явцын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголтыг буй болгодог” (Introduction to psycholinguistics: Understanding language science, 2012, хууд. 15) хэмээн дурдсан бол судлаач Р.В.Гиббс “Үгийн утгыг бүрэн ойлгож, тухайн агшинд утга хэрхэн үүсэж буйг олж мэдэхийн тулд танин мэдэхүйн хэл шинжлэлийн онолыг сэтгэц хэл шинжлэлийн туршилтын аргуудтай нэгтгэх шаардлагатай” (Embodiment and cognitive science, 2006, хууд. 233) хэмээн үзжээ.

Сэдвийн судлагдсан байдлыг тоймлон авч үзвэл монгол хэл шинжлэлд тэмдэг нэрийг бүтэц, байр, үүрэг, хэлбэрийн талаас нь судалсан нэг сэдэвт бүтээл, судалгааны өгүүлэл, диссертаци цөөнгүй буй. Мөн тэмдэг нэрсээс өнгөний нэрийг сонгон утгын өргөсөл, утгын хүрээ зэргийг танин мэдэхүйн хэл шинжлэлийн онол, арга зүйгээр судлан шинжилсэн

ажлууд мэр сэр бий. Харин монгол хэлний хэмжээ, хэмжигдэхүүн заасан тэмдэг нэрсийг дээр дурдсан онол, арга зүйгээр судалсан нь хараахан үгүй бололтой.

Англи хэлийг орчин үеийн хэл шинжлэлийн онол-арга зүйгээр судалсан ажлуудаас үзвэл танин мэдэхүйн хэл шинжлэлийн голлох төлөөлөгчид болох Жорж Лакофф, Марк Жонсон, Роналд Лангакер, Леонард Талми нарын бүтээлүүдэд зүйрлэлийг авч үзээгүй тохиолдол бараг үгүй бөгөөд эдгээрт “гүн”-ий зүйрлэлийн талаар дурдан, тайлбарласан байдаг. Тухайлбал, “*Дээш-доош, дотор-гадна, урд-ард, гүн-гүехэн, төв-зах* зэрэг орон зайн чиг баримжаа нь бидний биеийн болон соёлын туршлагад тулгуурладаг. Эдгээр нь үндсэн зүйрлэлийн концептууд болдог.” (Lakoff, G., Johnson, M, 1980, хууд. 14), “Өнгөн ба гүний талаарх биеийн туршлага нь хийсвэр сэтгэлгээг бий болгох үндсэн бүтцийг үүсгэдэг. “Гүн санаа” эсвэл “өнгөц ажиглалт” гэсэн зүйрлэл нь биеийн туршлагад үндэслэсэн хоёр хийсвэр бүдүүвчээр үүссэн юм.” (Johnson, 1987, хууд. 21), “Семантик бүтэц нь угаас л нэвтэрхий толь бичиг юм. Иймээс сэтгэхүй, сэтгэл хөдлөлийн хүрээнд “гүн” гэх зэрэг орон зайн концептын үүсгэж буй утгын өргөсөл нь хэл шинжлэлийн утгын гол хэсэг болно.” (Langacker, 1987, хууд. 154), “Орон зайн бүтэц нь орон зайн бус хүрээнүүдийг зохион байгуулах үндсэн концептын хүрээг бүрдүүлдэг. Сэтгэцийн үзэгдлийн “гүн” гэх зэрэг хэмжээст нэр томъёог ашиглах нь зүйрлэн дүрслэх ерөнхий үйл явцыг харуулдаг.” (Talmy, 2000, хууд. 172) хэмээн тус тус үзжээ.

Мөн “гүн”-ий зүйрлэлийг тусгайлан судалсан дараах өгүүллүүд байна. Үүнд:

- Foehl, J. C. (2014). A phenomenology of depth. *Psychoanalytic Dialogues*, 24(3), 289-303. doi:<https://doi.org/10.1080/10481885.2014.911597>
- Kroth, M., Carr-Chellman, D. (2020). Conceptualizing profundity through metaphor. *New Horizons in Adult Education and Human Resource Development*, 32(1), 5-16. doi:<https://doi.org/DOI:10.1002/nha3.20269>
- Kuiken, D. (2013). Understanding the depth metaphor in aesthetic experience: Pressing the limits of psychological inquiry. In *Toward a psychology of persons*, 101-117. doi:<https://doi.org/10.1037/drm0000067>
- Liu, Z. (2020). On the metaphor of embodied cognition from the perspective of depth psychology. *International Conference on Social Sciences and Innovative Economy (SSIE2020)* (pp. 259-262). Guangzhou: Oriental Academy for Analytical Psychology (OAAP).
- Wachtel, P. L. (2003). The surface and the depths: The metaphor of depth in psychoanalysis and the ways in which it can mislead. *Contemporary Psychoanalysis*, 39(1), 5-26. doi: <https://doi.org/10.1080/00107530.2003.10747197> гэх мэт.

Эдгээр өгүүлэлд “гүн”-ий зүйрлэлийг аль талаас нь хэрхэн судалсныг товч тайлбарлавал, судлаач П.Л.Вахтел психо-анализ дахь “гүн”-ий зүйрлэлийг шүүмжилж, “гүн” нь илүү үнэн юм уу далд утгыг илэрхийлдэг ч төөрөгдүүлж болзошгүй гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, “гүн”-ий зүйрлэлийг психо-анализын хувьд гол болгосон боловч төөрөгдүүлэхүйц ойлголтын хүрээ болгон судалжээ. Судлаач М.Крот, Д.Карр-Челлман нар насанд хүрэгчдийн боловсрол, хүний нөөцийн хөгжлийн талаарх гүн гүнзгий ойлголтыг хүмүүс “гүн”-ий зүйрлэлээр хэрхэн ойлгож, харилцаж байгааг судалсан бол судлаач Д.Күйкен нь гоо зүйн туршлага, ялангуяа урлаг, уран зохиол дахь “гүн”-ий зүйрлэлийг судалсан байна. Ингэхдээ урлагаар дамжуулж “гүн” туршлага, мэдрэмжийг хэрхэн олж авч болохыг, мөн “гүн”-ий зүйрлэл эдгээр туршлагыг хэрхэн зохион байгуулдгийг судалжээ. Мөн судлаач Ж.К.Фойл психо-аналитик харилцан ярианд “гүн” нь амьд зүйрлэл болж хэрхэн хэрэглэгдэж буйг судалж, үүнийг оюун санааны давхарга гэж үзэхээс илүүтэй туршлага, харилцааны шинж чанартай холбон үзжээ. Сүүлийн өгүүлэлд судлаач З.Лю нь танин мэдэхүйн онолыг психо-анализтай холбож, “гүн”-ий зүйрлэл нь танин мэдэхүйн үндэс суурийг хэрхэн дүрслэн харуулдгийг судалсан байна. Тэрээр “гүн”-ий зүйрлэл нь танин

мэдэхүйд бие, оюун ухаан, ухамсаргүй байдлын нэгдмэл шинж чанарыг харуулж байдаг тул сэтгэл судлал, хэл шинжлэлийн аль алинтай ойр холбоотой гэж дүгнэсэн байна.

Судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн:

Уг судалгааны нэгдүгээр үе шатанд МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн 1 дүгээр анги (зарим тохиолдолд 2-4 дүгээр анги)-ийн 157 оюутан (эрэгтэй 17, эмэгтэй 140)-ыг, 2 дугаар үе шатанд мөн оюутнуудаас 100 (эрэгтэй 12, эмэгтэй 88)-г нь хамруулав. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо тухайн бүлэг нь монгол хэл болон сэтгэл судлалын холбогдох хичээлүүдийг судалж буй, хэлний чадварын хувьд харьцангуй ижил түвшинд байгаа зэрэг шалгуурыг харгалзан үзэв.

Судалгааны арга зүйн хувьд хоёр үндсэн туршилт хийв.

1. Утгын холбоосын туршилт. Сэтгэц хэл шинжлэл, сэтгэл судлал, нийгэм судлал, сэтгэцийн эмнэл зүй зэрэг шинжлэх ухаанд идэвхтэй хэрэглэдэг арга юм. Уг туршилтын үр дүнг хэл шинжлэлийн олон салбарт ашиглах боломжтой. Үгсийн хоорондох утга зүйн хамаарал /semantic distance/-ыг тооцоолох нөхцөл бүрдүүлдгээс гадна үгийн утгад сэтгэл зүйн бүрдэл байдгийг харуулж, үгийн утга зүйн бүтцийг байгуулах боломж олгодог. Мөн утга зүйн орон /semantic field/ хэмээх ойлголтын сэтгэл зүйн тэнцлийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болж, өгүүлэгчдийн сэтгэц дэх үгсийн бодит утга зүйн холбоосыг илрүүлдэг. Хамгийн том давуу тал нь энгийн, хэрэглэхэд хялбар бөгөөд олон оролцогчийг хамруулах боломжтой байдаг оршино. (Белянин, 2016, хуудсд. 208-210)

Оролцогчдыг танхимд суулгаж, дараах алхмын дагуу туршилтыг гүйцэтгэв. Үүнд:

- Туршилтын зорилго, зориулалтыг танилцуулав.
- Туршилтын талаар товч мэдээлэл өгөв.
- Утгын холбоосын туршилтыг чөлөөт хэлбэрээр хийх, өөрөөр хэлбэл, аль ч үгийн аймгийн үгсийг санаанд орж буй дарааллаар дугаарлан бичихийг зааварчлав.
- Оролцогчдын нас, хүйсийг бичүүлээд, материалыг дугаарлаж авав.

Оролцогчдын материалыг MS Office Excel программд оруулж, AntConc программаар ерөнхий давтамжийг гаргав. Үүний дараа холбоос үүсгэсэн үгсийн дараалал (хэдэд бичигдсэн үг)-ыг харгалзан оноожуулав. Өдөөгч үг “гүехэн”-тэй холбоос үүсгэсэн үгс хамгийн олондоо 20 байсан тул 0.5-10 хүртэл оноог томьёогоор тохируулав (нэг үг 0.5 оноо). Өдөөгч үг “гүн”-тэй холбоос үүсгэсэн үгс хамгийн олондоо 16 байсан хэдий ч онооны дээд ба доод цэгийг адил барьснаар харьцуулах боломж бүрдэнэ хэмээн үзэж мөн 10 хүртэлх оноогоор тооцов. Хамгийн эхэнд бичигдсэн үг хамгийн өндөр оноо (10), хамгийн сүүлийн үг хамгийн бага оноо (0.5)-той байхаар буюу шугаман буурах зарчмаар тооцоолж $=IF(E2="", "", IF(G2=1, 10, 0.5 + (10 - 0.5) * (1 - (E2 - 1) / (G2 - 1))))$ томьёог оруулав.

Үгсийг оноожуулсны дараа MS Office Excel программд Pivot Table үүсгэж үг бүрийн давтамж болон онооны нийлбэрийг зэрэгцүүлэн харав. Ингэснээр *гүн* ба *гүехэн* хэмээх үгсийн утгын холбоос үүсгэх онцлогийг хоёр хэмжээс (давтамж ба онооны жин)-ээр харьцуулж, хамгийн өргөн хэрэглэгддэг болон сэтгэцэд хамгийн ойр, нэн түрүүнд сэрэгддэг үгсийг ялган дүгнэх боломж бүрдэв.

Хоёр өдөөгч үг тус бүрээс хамгийн өндөр нийлбэр оноотой 20 холбоо үгийг ялгаж удаах туршилтыг хийв.

2. Утгын ялгамжийн туршилт. Хоёр туйлт чанарын шатлан эрэмбэлсэн үзүүлэлтээр байгаль, нийгмийн хүн амьтан, юмс үзэгдлийг үнэлэх сэтгэц хэл шинжлэлийн туршилт судалгааны арга. Энэ нь сэтгэц хэл шинжлэл болон сэтгэц-утга зүй /psycho-semantics/-н арга

бөгөөд субъектив семантик орон зайг байгуулах, хэмжээсжүүлэхтэй холбоотой. Хэмжүүрийн аргуудыг сэтгэл судлалд тодорхой объектын талаарх хандлагыг тоон үзүүлэлтээр үнэлэх зорилгоор хэрэглэдэг. Сэтгэц хэл шинжлэлд үг нь судалгааны объект болох бөгөөд уг арга нь хүний ухамсар, зан үйлийн онцлог, мөн нийгмийн хандлага болон хувийн өвөрмөц утгын шинжилгээнд өргөн хэрэглэгддэг. Энэ аргыг сэтгэл судлал, сэтгэцийн эмнэл зүй, сэтгэц оношилгоонд ашиглах нь элбэг. Харин хэл шинжлэлийн хувьд уг аргын сонирхолтой нь, үгийн утгын цоо шинэ талуудыг илрүүлдэг явдал юм (Белянин, 2016, хуудсд. 213, 217). Уг судалгааны арга нь хэлбэрийн хувьд утгын ялгамжийн туршилт мөн боловч агуулгын хувьд зүйрлэл ойлгох туршилт болж буйг тэмдэглэе.

Нэгдүгээр туршилтыг хийснээс 7 хоногийн дараа дараах алхмаар хоёрдугаар туршилтыг гүйцэтгэв. Үүнд:

- Туршилтын талаар товч мэдээлэл өгөв.
- Хамгийн өндөр нийлбэр оноотой 20 холбоо үгийн жагсаалт бүхий хэмжээсжүүлэн үнэлэх хүснэгтийг тарааж өгөв.
- Нэмэх хоёроос хасах хоёр буюу 5 шатлалт хэмжээсээр үнэлэхийг зааварчилж, хэмжээс тус бүрийн ялгааг тайлбарлаж өгөв. Үүнд:
 - +2 – 100% шууд утгатай
 - +1 – Утгын 75% нь шууд утга, 25% нь зүйрлэл
 - 0 – Утгын 50% нь шууд утга, 50% нь зүйрлэл
 - -1 – Утгын 75% нь зүйрлэл, 25% нь шууд утга
 - -2 – 100% зүйрлэлийн утгатай

Оролцогчдын гүйцэтгэсэн материалыг MS Office Excel программд оруулж, Pivot Table үүсгэж 20 холбоо үг тус бүрийн дундаж оноог гаргав.

Үндсэн хэсэг:

Үр дүн: Туршилтын нэгдүгээр үе шатны үр дүнг жишээлэн харуулъя. 1.1-р хүснэгтэд 157 оролцогчийн датаг цахимд оруулахад өдөөгч үг “гүн”-тэй холбоос үүсгэсэн үгс 1129 (давхардсан тоогоор), 266 (давхардаагүй тоогоор), нэг оролцогчийн бичсэн дундаж үгийн тоо 8.5 байв. Харин, өдөөгч үг “гүехэн”-тэй холбоос үүсгэсэн үгс нийт 652 (давхардсан тоогоор), 209 (давхардаагүй тоогоор), нэг оролцогчийн бичсэн дундаж үгийн тоо 7.2 байв. Эндээс давтамжийн доод түвшний буюу 1-2 удаа бичигдсэн үгсийг хувийн шинжтэй, ойлголтын зөрүүтэй хэмээн үзэж, зөвхөн хамгийн өндөр давтамжтай 20 үгийг сонгон дүн шинжилгээ хийв. Эдгээр үг нь монгол хэлээр хэлэлцэгчид (тухайн бүлэг)-ийн дунд хамгийн нийтлэг, тогтвортой бөгөөд хамтын шинжийг илтгэх боломжтой юм.

1.1-р хүснэгт. Утгын холбоосын туршилт судалгааны үр дүн

Оролцогчийн №	Нас	Хүйс	Өдөөгч үг	Дараалал	Холбоос үүсгэсэн үг	Оноо
1	18	эм	Гүн	1	Гүнзгий	10.000
1	18	эм	Гүн	2	Цэнхэр	9.136
1	18	эм	Гүн	3	Ухаантан	8.273
1	18	эм	Гүн	4	Далай	7.409
1	18	эм	Гүн	5	Бодол	6.545
1	18	эм	Гүн	6	Сэтгэл	5.682
1	18	эм	Гүн	7	Тод	4.818
1	18	эм	Гүн	8	Хязгааргүй	3.955
1	18	эм	Гүн	9	Ангал	3.091
1	18	эм	Гүн	10	Агуй	2.227
1	18	эм	Гүн	11	Асар	1.364

1	18	эм	Гүн	12	Ёроолгүй	0.500
1	18	эм	Гүехэн	1	Мөчидхөн	10.000
1	18	эм	Гүехэн	2	гол горхи	8.643
1	18	эм	Гүехэн	3	Бага	7.286
1	18	эм	Гүехэн	4	Өчүүхэн	5.929
1	18	эм	Гүехэн	5	Богино	4.571
1	18	эм	Гүехэн	6	Намхан	3.214
1	18	эм	Гүехэн	7	ахар бодолтой	1.857
1	18	эм	Гүехэн	8	Өнгөцхөн	0.500

Холбоос үүсгэсэн үгсийн онооны нийлбэр ба давтамжийг гаргаж, уг судалгаанд онооны нийлбэр нь харьцангуй чухал үзүүлэлт тул дарааллыг 1.2-р хүснэгтэд үзүүлсэнчлэн гаргав. Өдөөгч үг “гүн”-ий тухайд хамгийн хүчтэй холбоос үүсгэсэн үг “ухаан” 526.84 оноотой, 157 оролцогчийн 50.9% нь бичсэн бол “гүехэн”-ий тухайд хамгийн хүчтэй холбоос үүсгэсэн үг “гол” 536.50 оноотой, 17 оролцогчийн 54.14% нь бичсэн байна. Судалгаанд оролцогчдын бичсэн нийт үг (1781)-ийн оноо, давтамжийг харуулахад нүсэр тул хамгийн өндөр оноотой 20 холбоо үгийг хүснэгтэд үзүүлэв.

1.2-р хүснэгт. Холбоос үүсгэсэн үгсийн давтамж ба онооны жин

Холбоос үүсгэсэн үг /гүн/	Онооны нийлбэр	Давтамж	Холбоос үүсгэсэн үг /гүехэн/	Онооны нийлбэр	Давтамж
1. ухаан	526.84	80	1. гол	536.50	85
2. гүнзгий	390.60	82	2. ус	500.56	85
3. бодол	299.61	73	3. нуур	218.83	44
4. харанхуй	233.23	39	4. бодол	109.45	26
5. ус	218.59	43	5. сэтгэл	55.38	10
6. нүх	209.86	47	6. цөөрөм	52.80	12
7. далай	207.52	47	7. ухах	42.00	8
8. нуур	203.67	37	8. газар	41.13	12
9. худаг	155.81	29	9. далай	40.03	10
10. агуй	112.91	22	10. шалбааг	38.39	9
11. гол	110.80	20	11. намаг	35.25	8
12. утга	72.83	19	12. санаа	34.31	9
13. ухах	62.49	19	13. бага	32.82	7
14. сэтгэл	60.57	21	14. эрэг	26.96	5
15. ангал	48.68	13	15. амьтан	26.39	6
16. дурлал	48.24	15	16. нүх	24.23	9
17. хар	43.64	11	17. жижиг	22.00	5
18. нойр	43.17	14	18. намхан	21.79	5
19. хавцал	41.16	10	19. нам	20.32	4
20. хайр	39.13	14	20. ухаан	20.16	7

Туршилтын хоёрдугаар үе шатны үр дүнг харуулбал дараах байдалтай байна. 2.1-р хүснэгтэд үзүүлсэнчлэн 100 оролцогчийн 20 холбоо үгийг хэмжээсжүүлэн үнэлсэн нийт 2000 оноог цахимд оруулав.

2.1-р хүснэгт. Утгын ялгамж тодорхойлох туршилт судалгааны үр дүн

Оролцогчийн №	Нас	Хүйс	Өдөөгч үг	Холбоос үүсгэсэн үг	Оноо
1	18	эм	Гүн	гүн ухаан	0
1	18	эм	Гүн	гүн гүнзгий	1
1	18	эм	Гүн	гүн бодол	-2
1	18	эм	Гүн	гүн харанхуй	0

1	18	эм	Гүн	гүн ус	2
1	18	эм	Гүн	гүн нүх	2
1	18	эм	Гүн	гүн далай	2
1	18	эм	Гүн	гүн нуур	2
1	18	эм	Гүн	гүн худаг	2
1	18	эм	Гүн	гүн агуй	2
1	18	эм	Гүн	гүн гол	2
1	18	эм	Гүн	гүн утга	-2
1	18	эм	Гүн	гүн ухах	2
1	18	эм	Гүн	гүн сэтгэл	-2
1	18	эм	Гүн	гүн ангал	2
1	18	эм	Гүн	гүн дурлал	-2
1	18	эм	Гүн	гүн хар	1
1	18	эм	Гүн	гүн нойр	-1
1	18	эм	Гүн	гүн хавцал	2
1	18	эм	Гүн	гүн хайр	-2
1	18	эм	Гүехэн	гүехэн гол	2
1	18	эм	Гүехэн	гүехэн ус	2
1	18	эм	Гүехэн	гүехэн нуур	2
1	18	эм	Гүехэн	гүехэн бодол	1
1	18	эм	Гүехэн	гүехэн сэтгэл	-2
1	18	эм	Гүехэн	гүехэн цөөрөм	2
1	18	эм	Гүехэн	гүехэн ухах	2
1	18	эм	Гүехэн	гүехэн газар	2
1	18	эм	Гүехэн	гүехэн далай	2
1	18	эм	Гүехэн	гүехэн шалбааг	2
1	18	эм	Гүехэн	гүехэн намаг	2
1	18	эм	Гүехэн	гүехэн санаа	0
1	18	эм	Гүехэн	гүехэн бага	2
1	18	эм	Гүехэн	гүехэн эрэг	2
1	18	эм	Гүехэн	гүехэн амьтан	2
1	18	эм	Гүехэн	гүехэн нүх	2
1	18	эм	Гүехэн	гүехэн жижиг	2
1	18	эм	Гүехэн	гүехэн намхан	2
1	18	эм	Гүехэн	гүехэн нам	0
1	18	эм	Гүехэн	гүехэн ухаан	0


Утгын ялгамж тодорхойлох туршилт судалгааны үр дүнгийн дундаж оноог ерөнхийлөн харвал өдөөгч үг тус бүрийн 20 холбоо үгээс 14 нь шууд утгатай, 6 нь зүйрлэлийн утгатай байв. Өдөөгч үг “гүн”-ий хувьд хамгийн их шууд утгатай нь “гүн худаг” 1.77 оноо, хамгийн их зүйрлэлийн утгатай нь “гүн сэтгэл” -1.08 оноо гарсан бол, өдөөгч үг “гүехэн”-ий хувьд хамгийн их шууд утгатай нь “гүехэн нуур” 1.45 оноо, хамгийн их зүйрлэлийн утгатай нь “гүехэн сэтгэл” -1.2 оноо гарав. 5 хэмжээст оноонд ангилан харвал:

- Бүхэлдээ шууд утга бүхий холбоо үг: өдөөгч үг “гүн”-д 10, “гүехэн”-д 8,
- Дийлэнх нь шууд утга бүхий холбоо үг: “гүн”-д 4, “гүехэн”-д 6,
- Дийлэнх нь зүйрлэл бүхий холбоо үг: “гүн”-д 5, “гүехэн”-д 2,
- Бүхэлдээ зүйрлэлийн утгатай холбоо үг: “гүн”-д 1, “гүехэн”-д 4 гэсэн үр дүн гарсан байна.

2.2-р хүснэгт. Зүйрлэл ойлгох туршилт судалгааны үр дүн

Холбоос үүсгэсэн үгс	Дундаж оноо	Зүйрлэл/шууд утга	Холбоос үүсгэсэн үгс	Дундаж оноо	Зүйрлэл/шууд утга
гүн худаг	1.77	Бүхэлдээ шууд утга	гүехэн нуур	1.45	Бүхэлдээ шууд утга
гүн ухах	1.57		гүехэн гол	1.44	
гүн нүх	1.57		гүехэн ус	1.42	
гүн агуй	1.56		гүехэн цөөрөм	1.34	
гүн нуур	1.54		гүехэн ухах	1.23	
гүн гол	1.49		гүехэн нүх	1.23	
гүн далай	1.45		гүехэн шалбааг	1.18	
гүн ус	1.34		гүехэн намаг	1.18	
гүн хавцал	1.17		гүехэн далай	0.96	
гүн ангал	1.13		гүехэн газар	0.89	
гүн гүнзгий	0.73	Дийлэнх нь шууд утга	гүехэн эрэг	0.85	Дийлэнх нь шууд утга
гүн харанхуй	0.34		гүехэн намхан	0.27	
гүн нойр	0.21		гүехэн нам	0.17	
гүн хар	0.02		гүехэн жижиг	0.1	
гүн ухаан	-0.3	Дийлэнх нь зүйрлэл	гүехэн амьтан	-0.21	Дийлэнх нь зүйрлэл
гүн бодол	-0.46		гүехэн бага	-0.21	
гүн утга	-0.73		гүехэн санаа	-1	Бүхэлдээ зүйрлэл
гүн дурлал	-0.77		гүехэн бодол	-1.04	
гүн хайр	-0.88		гүехэн ухаан	-1.12	
гүн сэтгэл	-1.08	Бүхэлдээ зүйрлэл	гүехэн сэтгэл	-1.2	
НИЙТ	0.58		НИЙТ	0.44	

1-р зураг. Зүйрлэл ойлгох туршилтын үр дүнгийн график



Хэлэлцүүлэг: Тус судалгаагаар “гүн” ба “гүехэн” хэмээх үгсийн утгын өргөсөл, тэдгээрээр үүсэх зүйрлэлийг шинжлэн судлахыг зорьсноо дээр дурдсан буй. Утгын өргөслийг ажиглахын тул монгол хэлний тайлбар толь бичгүүд дэх хоёр үгийн үндсэн (I) утгыг авч үзье.

ГҮН V-1. нягт их; гүн ой; гүн шугуй (Цэвэл, 1966), ГҮН-Аливаа гол нуурын ус ёроол олохгүй газрыг гүн хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 1977), ГҮН-Гүехэн бусыг гүн хэмээмүй. Далай мөрөн мэтийг гүн хэмээмүй. Бас эрдэм ухаан ихийг гүн хэмээмүй. Жич, улаан

өнгийн маш хурц дурдмыг гүн улаан хэмээмүй. Бас цөл, бэрх уулыг гүн уул хэмээмүй. (Хорин наймт тайлбар толь, 1988), ГҮН. Гүехний эсрэг утга, дээрээс доор, гаднаас дотор хүртэлх зай нь их: гүн ус; гүн уул; гүн гэр; гүн худаг (Сэцэнцогт, Монгол үгсийн язгуурын толь, 1988), ГҮН gүн-(гэм) 1. Дээрээс доор хүртэлх зай буюу газраас дотор хүрэх эзлэхүүн нь их: Гүн ус; гүн уул. Таван хос алд гүн худаг (Норжин, Монгол хэлний толь, 1997).

ГҮЕХЭН 1. Нэлээд гүен, гүн биш: гүехэн болох (гүн биш болох) - Эрэг ойртож ус гүехэн болов. дэлгэрэнгүй... гүехэн гэх (гүн биш гэх) - Далайн хөвөөнд биеэ угаагаад далайг гүехэн үзсэнээс юун өөр буй. В.Инжаннаши. Хөх судар (Монгол хэлний их тайлбар толь, 2016), ГҮЕХЭН-Усны нимгэнийг гүехэн хэмээмүй. Бас санаа мөчид хүнийг гүехэн хэмээмүй. Ер аливаа гүн бусыг гүехэн хэмээмүй (Хорин наймт тайлбар толь, 1988).

“Гүн” ба “гүехэн” хэмээх үгсийн утгын холбоосын туршилтын үр дүнгээр илэрсэн 20 холбоо үгийг танин мэдэхүйн хэл шинжлэлд түгээмэл хэрэглэгддэг утгын хүрээ /domain/-нүүдэд ангилан үзэв.

3.1-р хүснэгт. Утгын хүрээний ангилал

Шууд утга/ Сурвалж хүрээ	Оюун санаа, танин мэдэхүйн хүрээ	Сэтгэл хөдлөлийн хүрээ	Үл мэдэгдэх, нууцын хүрээ	Ухамсар, мэдрэлийн хүрээ
1. Гүн ус 2. Гүн нүх 3. Гүн далай 4. Гүн нуур 5. Гүн худаг 6. Гүн агуй 7. Гүн гол 8. Гүн ухах 9. Гүн ангал 10. Гүн хавцал	1. Гүн ухаан 2. Гүн бодол 3. Гүн утга	1. Гүн сэтгэл 2. Гүн дурлал 3. Гүн хайр	1. Гүн гүнзгий 2. Гүн хар 3. Гүн харанхуй	1. Гүн нойр
1. Гүехэн гол 2. Гүехэн ус 3. Гүехэн нуур 4. Гүехэн цөөрөм 5. Гүехэн ухах 6. Гүехэн газар 7. Гүехэн далай 8. Гүехэн шалбааг 9. Гүехэн намаг 10. Гүехэн бага 11. Гүехэн эрэг 12. Гүехэн нүх 13. Гүехэн жижиг 14. Гүехэн намхан 15. Гүехэн нам	1. Гүехэн бодол 2. Гүехэн санаа 3. Гүехэн ухаан	1. Гүехэн сэтгэл		

Дээрх хүснэгтээс харахад гүн хэмээх үгээр үүссэн 20 холбоо үгийг таван утгын хүрээнд тархаан хувааж болохуйц буюу утгын өргөсөл сурвалж хүрээнээс цааш дөрвөн хүрээ рүү шилжин өргөссөн байна. Гүехэн хэмээх үгээр үүссэн 20 холбоо үгийн 75% нь шууд утгаараа буюу сурвалж хүрээнд багтаж, утгын өргөсөл цөөн, зөвхөн оюун санааны болон сэтгэл хөдлөлийн хүрээ рүү шилжин явагджээ.

Тухайн утгын өргөслүүдээс “Ухаан/бодол бол далай”, “Хайр/сэтгэл бол далай”, “Хар өнгө бол далай”, “Зүүд нойр бол далай” гэсэн концептуал зүйрлэлүүд үүссэн нь ажиглагдаж байна. Эдгээр концептуал зүйрлэлийн үүссэн шалтгааныг тайлбарлахын тулд чиглэлийн зүйрлэл /orientational metaphor/-ын онцлогийг авч үзье. Судлаач Ж.Лакофф, М.Жонсон нар “Гэвч өөр нэг төрлийн зүйрлэл байдаг бөгөөд энэ нь нэг ойлголтыг нөгөөгөөр төлөөлдөггүй, харин бүхэл ойлголтын тогтолцоог уялдаагаар нь зохион байгуулдаг. Үүнийг бид чиглэлийн зүйрлэл гэж нэрлэв. Учир нь тэдгээрийн ихэнх нь орон зайн чиглэлтэй холбоотой байдаг: *дээш-доош, дотор-гадаа, урагш-хойш, гүн-гүехэн, төв-зах*. Эдгээр орон зайн чиглэл нь бидний биеийн онцлог шинж болон хүрээлэн буй орчинтой хэрхэн харилцан үйлчилдгээс үүдэн бий болдог” (2003, хууд. 15) хэмээн үзжээ. Эндээс ажиглавал, хүн их усны гүн рүү доош харахад ёроол нь үл үзэгдэх, хэмжихийн аргагүй, тайлагдашгүй байдлыг мэдэрдэг. Иймээс “гүн” хэмээх орон зайн ойлголт нь оюун санаа/танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, ухамсар, мэдрэхүйн түвшинд шилжихдээ “Ухаан/бодол бол далай”, “Хайр/сэтгэл бол далай”, “Хар өнгө бол далай”, “Зүүд нойр бол далай” гэсэн концептуал зүйрлэлүүдийг үүсгэжээ. Товч тайлбарлавал:

- “Ухаан/бодол бол далай” гэсэн зүйрлэл нь далайн гүний тайлагдашгүй, хэмжиж үл болох шинжээр төлөөлүүлэн ухаан, бодлын ойлгоход бэрх, нарийн төвөгтэй байдлыг илэрхийлж буй. Ухаан, бодол гүн тусам ойлгоход хэцүү, сайтар тунгаахан гэж хүмүүс үздэг нь “гүн” хэмээх орон зайн туршлагыг танин мэдэхүйн хүрээ /cognitive domain/ рүү шилжүүлсэн концептуал зүйрлэлийн илрэл юм.
- “Хайр/сэтгэл бол далай” гэсэн зүйрлэл нь далайн гүний тайлагдашгүй, хэмжиж үл болох төдийгүй гүн ёроолдоо хөдөлгөөнгүй, тогтвортой оршдог шинжээр төлөөлүүлэн хайр, сэтгэлийн хязгааргүй болон чин үнэн, хувиршгүй байдлыг илэрхийлж буй. Энэ нь сэтгэл хөдлөлийг орон зайн гүнзгийрлээр танин мэдэх үйл явцын илрэл юм.
- “Хар өнгө бол далай” гэсэн зүйрлэл нь нуур далай зэрэг их усны ёроол руу харахад нууцлаг, үл мэдэгдэх харанхуй, хар өнгө үзэгддэгээс үүссэн бөгөөд мэдрэхүйн хүрээ /perceptual domain/ болон танин мэдэхүйн хүрээ /cognitive domain/ хоорондын буулгалт /mapping/-аар үүссэн жишээ юм. Хар өнгийг далайн гүнтэй адилтгах нь мэдрэхүйн туршлага /perceptual experience/-ыг хийсвэр ойлголт руу шилжүүлэх үйл явц болно.
- “Зүүд/нойр бол далай” гэсэн зүйрлэлд далайн гүн нь дуугүй, гадарга дахь үйл явц, хүн юмсыг анзаарч мэдэхгүй гэсэн шинжээрээ зүүд, нойрны ухамсаргүй байдал /unconsciousness/ болон мэдрэхүйн гүн /perceptual depth/-ийг илэрхийлж буй. Энэ нь ухамсар ба ухамсаргүйн заагийг илэрхийлэх орон зайн зүйрлэл /spatial metaphor of consciousness/ бөгөөд нойр гүн байх тусам эргэн тойрон болж буй зүйлсийг мэдрэхгүй бат бөх унтах гэсэн утгыг илтгэнэ.

Мөн эдгээр концептуал зүйрлэлд хүний биеийн бүтэц, мэдрэхүйн туршлага ч нөлөөлсөн байх магадлалтай. Учир нь ухаан, бодол, сэтгэл, хайр зэрэг оюун сэтгэлийн үйл явцыг бид гаднаас харагдах биеийн эрхтнүүдэд бус, хүний биеийн үл харагдах, дотоод гүн хэсэгт байрлах тархи, зүрхнээс үүсэн төрдөг хэмээн ойлгодог. Иймээс эдгээр концептуал зүйрлэл нь чиглэлийн зүйрлэл болохоос гадна биед суурилсан танин мэдэх үйл (embodied cognition)-ийн илэрхийлэл болж буй юм.

“Гүн” хэмээх хоёр өөр ойлголт зэрэгцэн оршиж байгааг анхаарах нь зүйтэй. “Барилга” болон “Сав”-ын зүйрлэлд гүн байх тусам илүү үндсэн, суурь гэсэн утга илэрхийлнэ. Харин “Аялал”-ын зүйрлэлд гүн нь ил тод бус зүйлсийг илтгэнэ. Гадаргуу дээр бус, нүдэнд ил харагдахгүй байгаа баримтуудыг бид “гүнзгийрч судлах” шаардлагатай болдог (2003, хууд. 101) хэмээн мөн судлаач Ж.Лакофф, М.Жонсон нар тайлбарлажээ. Бидний өгүүлэн буй концептуал зүйрлэлүүд “Сав”-ын зүйрлэлтэй түлхүү ижилсэн тохирно. Учир нь гүнээр хэмжиж буй ус, далай, нуур, гол, худаг гэх мэт физик биет бүгд эзэлхүүнтэй, дээд гадаргаас доод ёроол хүртэлх зайг хэмжих талаар яригдах ойлголтууд юм.

Хоёр өдөөгч үгийн утгын холбоосын болон утгын ялгамж тодорхойлох туршилтын үр дүнг харьцуулахад үүссэн холбоо үг болон утгын өргөслийн хүрээний тоогоор “гүн” хэмээх үг нь “гүехэн”-ээс харьцангуй илүү буй нь монгол хэл соёлтны буюу туршилтад оролцсон тухайн бүлгийн хэлний хэрэглээний онцлогоос шалтгаалж буй хэмээн үзэж байна.

3.2-р хүснэгт

Өдөөгч үгсийн туршилтын үр дүнгийн харьцуулал

Өдөөгч үг	Утгын холбоосын туршилтын үр дүн	Утгын ялгамж тодорхойлох туршилтын үр дүн
Гүн	266 холбоо үг бичигдсэн	Утгын өргөсөл 4 хүрээнд явагдсан
Гүехэн	209 холбоо үг бичигдсэн	Утгын өргөсөл 2 хүрээнд явагдсан

Дүгнэлт:

- Тус туршилт судалгааны эхний шат (утгын холбоосын туршилт)-ны үр дүнд “гүн” хэмээх үгтэй холбоос үүсгэдэг 266, “гүехэн” хэмээх үгтэй холбоос үүсгэдэг 209 үгийг 18-22 насны оюутны бүлгийн хүрээнд илрүүлэв. Үүнээс “гүн ухаан, гүн гүнзгий, гүн бодол, гүн харанхуй, гүн ус, гүн нүх, гүн далай, гүн нуур, гүн худаг, гүн агуй, гүн гол, гүн утга, гүн ухах, гүн сэтгэл, гүн ангал, гүн дурлал, гүн хар, гүн нойр, гүн хавцал, гүн хайр”; “гүехэн гол, гүехэн ус, гүехэн нуур, гүехэн бодол, гүехэн сэтгэл, гүехэн цөөрөм, гүехэн ухах, гүехэн газар, гүехэн далай, гүехэн шалбааг, гүехэн намаг, гүехэн санаа, гүехэн бага, гүехэн эрэг, гүехэн амьтан, гүехэн нүх, гүехэн жижиг, гүехэн намхан, гүехэн нам, гүехэн ухаан” гэсэн тус бүр 20 (нийт 40) үг бичигдсэн дараалал болон давтамжийн хувьд хамгийн өндөр оноотой буюу судалгаанд оролцогч бүлгийн сэтгэцэд хамгийн ойр түргэн буудаг, өдөөгч үгтэй хамгийн хүчтэй холбоос үүсгэдэг болох нь харагдав.
- Тус туршилт судалгааны хоёрдугаар шат (утгын ялгамжийн туршилт)-ны үр дүнд өдөөгч үг “гүн”-тэй холбоос үүсгэсэн үгсийн 10 нь бүхэлдээ шууд утгатай, 4 нь утгын дийлэнх нь шууд утгатай, 5 нь дийлэнх нь зүйрлэлийн утгатай, 1 нь бүхэлдээ зүйрлэлийн утгатай гэж үзсэн байхад, өдөөгч үг “гүехэн”-тэй холбоос үүсгэсэн үгсийн 8 нь бүхэлдээ шууд утгатай, 6 нь дийлэнх нь шууд утгатай, 2 нь дийлэнх нь зүйрлэлийн утгатай, 4 нь бүхэлдээ зүйрлэлийн утгатай гэсэн үр дүн гарав. “Гүн” хэмээх үгийн утгын өргөсөл сурвалж хүрээнээс цааш 4 хүрээ рүү явагдсан бол, “гүехэн” хэмээх үгийнх зөвхөн 2 утгын хүрээ рүү явагдсаныг тухайн бүлгийн хэлний хэрэглээтэй холбоотой хэмээн үзэж байна.
- Зүйрлэл ойлгох туршилтын үр дүнд “Ухаан/бодол бол далай”, “Хайр/сэтгэл бол далай”, “Хар өнгө бол далай”, “Зүүд нойр бол далай” гэсэн концептуал зүйрлэлүүд үүссэнийг ажиглаж, хүн далайн гүний ёроол нь үл үзэгдэх, хэмжихийн аргагүй, тайлагдашгүй шинж; далайн гүний хөдөлгөөнгүй, тогтвортой шинж; далайн гүний нууцлаг, үл мэдэгдэх харанхуй, хар өнгө; далайн гүний дуугүй, гадарга дахь үйл явц, хүн юмсыг анзаарч мэдэхгүй зэрэг шинжээр төлөөлүүлэн бүтсэн хэмээн таамаглав. Мөн ухаан, бодол, сэтгэл, хайр, нойр зэрэг оюун сэтгэлийн үйл явцыг бид гаднаас харагдах биеийн эрхтнүүдэд бус, хүний биеийн үл харагдах, дотоод гүн хэсэгт байрлах тархи, зүрхнээс үүсэн төрдөг хэмээн ойлгодог тул эдгээр концептуал зүйрлэл нь биед суурилсан танин мэдэх үйлтэй холбоотой хэмээн үзэв.
- Тус туршилт судалгаагаар сэтгэцэд хамгийн ойр түргэн бууж, өдөөгч үгтэй хамгийн хүчтэй холбоос үүсгэдэг үгсийг илрүүлж, зүйрлэл ойлгох туршилтын үр дүнг концептуал зүйрлэлийн онолын үүднээс тайлбарлахыг оролдсон боловч судалгааны үр дүнд судалгаанд оролцогчдын нас, сэтгэхүйн онцлог, хэлний мэдрэмж, мэдлэг, үгийн

сангийн нөөц, түвшин нөлөөлсөн нь тус судалгааны хязгаарлагдмал тал болсныг тэмдэглэе.

A psycholinguistic investigation of the ‘depth’ metaphor in Mongolian

Tsog-Ochir Avirmed 

*Ph.D, professor, academic advisor of the Department of Mongolian language,
Mongolian National university of Education, Ulaanbaatar, Mongolia*

Ankhiluun Otgonbayar 

*Lecturer of the Department of Mongolian language,
Mongolian National university of Education, Ulaanbaatar, Mongolia*

Abstract: This study investigates the adjectives *gün* (“deep”) and *güyüken* (“shallow”) which denote dimensionality through two psycholinguistic experimental methods: the word association task and the semantic differential method. The research was conducted among a group of 100-157 university students aged 18-22. The stimulus word *gün* elicited 1129 associative responses in total (266 unique responses), with an average of 8.5 responses per participant. The word *güyüken* produced 652 associative responses (209 unique), averaging 7.2 responses per participant. Based on frequency and sequence, the 20 most salient associative words for each stimulus were selected and evaluated on a five-point semantic differential scale ranging from +2 to -2, where +2 indicates a completely literal meaning and -2 represents a fully metaphorical meaning. Comparison with dictionary definitions revealed that *gün* extended its meaning beyond its literal spatial domain into four semantic domains: cognitive/intellectual, emotional, psychological, and mysterious, while *güyüken* showed limited extension into only two domains, primarily cognitive and emotional. Conceptual analysis identified several conceptual metaphors, such as Mind/Thought is an Ocean, Emotion/Love is an Ocean, and Dream/Sleep is an Ocean. These metaphors demonstrate the cognitive embodiment of spatial experience, where “depth” reflects hiddenness and complexity rather than physical dimensionality. The findings are interpreted within the framework of Conceptual Metaphor Theory and Embodied Cognition, illustrating how spatial perception shapes abstract conceptualization in the Mongolian language.

Keyword: Cognitive linguistics, word-association experiment, semantic differential experiment, metaphor-comprehension experiment, conceptual metaphor

Ном зүй - References

- Foehl, J. C. (2014). A phenomenology of depth. *Psychoanalytic Dialogues*, 24(3), 289-303.
<https://doi.org/10.1080/10481885.2014.911597>
- Gibbs, R. W. (2006). *Embodiment and cognitive science*. Cambridge: Cambridge University Press.
<https://doi.org/10.1093/acprof:oso/9780195111095.003.0005>
- Glucksberg, S. (2001). *Understanding figurative language: From metaphors to idioms*. Oxford: Oxford University Press. <https://doi.org/10.1093/acprof:oso/9780195111095.001.0001>
- Johnson, M. (1987). *The body in the mind: The bodily basis of meaning, imagination, and reason*. Chicago: University of Chicago Press. <https://doi.org/10.1017/S0047404500014317>
- Kroth, M., Carr-Chellman, D. (2020). Conceptualizing profundity through metaphor. *New Horizons in Adult Education and Human Resource Development*, 32(1), 5-16.
<https://doi.org/10.1002/nha3.20269>
- Kuiken, D. (2013). Understanding the depth metaphor in aesthetic experience: Pressing the limits of psychological inquiry. In *Toward a psychology of persons*, 101-117.
<https://doi.org/10.1037/drm0000067>

- Lakoff, G., Johnson, M. (1980). *Metaphors we live by*. Chicago: University of Chicago Press.
- Lakoff, G., Johnson, M. (2003). *Metaphors we live by* (2nd ed.). Chicago: University of Chicago Press. <https://doi.org/10.7208/chicago/9780226470993.001.0001>
- Langacker, R. W. (1987). *Foundations of cognitive grammar: Vol. 1, Theoretical prerequisites*. Stanford: Stanford University Press. <https://doi.org/10.1017/S0008413100021265>
- Liu, Z. (2020). On the metaphor of embodied cognition from the perspective of depth psychology. *International Conference on Social Sciences and Innovative Economy (SSIE2020)* (pp. 259-262). Guangzhou: Oriental Academy for Analytical Psychology (OAAP).
- Talmy, L. (2000). *Toward a cognitive semantics: Vol. 1, Concept structuring systems*. Cambridge, MA: MIT Press. <https://doi.org/10.7551/mitpress/6847.001.0001>
- Taylor, J. R. (2002). *Cognitive grammar*. Oxford: Oxford University Press. <https://doi.org/10.1093/oso/9780198700333.001.0001>
- Traxler, M. J. (2012). *Introduction to psycholinguistics: Understanding language science*. Oxford: Wiley-Blackwell.
- Wachtel, P. L. (2003). The surface and the depths: The metaphor of depth in psychoanalysis and the ways in which it can mislead. *Contemporary Psychoanalysis*, 39(1), 5-26. <https://doi.org/10.1080/00107530.2003.10747197>
- Белянин, В. П. (2016). *Психоллингвистика (4-е изд., стереотипное)*. Москва: Флинта. [Belyanin, V. P. *Psikholingvistika [Psycholinguistics]* (4th ed.). Moscow: Flinta.]
- Монгол хэлний их тайлбар толь. (2016). Retrieved from Гүехэн: <http://www.mongoltoli.mn/> Mongol khelnii ikh tailbar toli. [Great Dictionary of the Mongolian Language]
- Норжин, Ц. (1997). *Монгол хэлний толь. Өвөрмонгол: Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо*. [Norjin, Ts. *Mongol khelnii toli. Dictionary of the Mongolian Language*. Uvurmongol: Uvur Mongoliin Ardiin Khevleliin Khoroo.]
- Сэцэнцогт, Н. (1988). *Монгол үгсийн язгуурын толь. Өвөрмонгол: ӨМАХХ*. [Setsentsogt, N. *Mongol ugsiin yazguuriin toli. Etymological Dictionary of Mongolian Words*. Uvurmongol: UMAKhKh.]
- Хорин наймт тайлбар толь. (1988). *Өвөрмонгол: Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо*. Khorin naimt tailbar toli. [Explanatory Dictionary Divided into Twenty-Eight Sections. Uvurmongol: Uvur Mongoliin Ardiin Khevleliin Khoroo.]
- Хорин нэгт тайлбар толь. (1977). *Өвөрмонгол: Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо*. Khorin negt tailbar toli. [Explanatory Dictionary Divided into Twenty-Eight Sections. Uvurmongol: Uvur Mongoliin Ardiin Khevleliin Khoroo.]
- Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо*. [Tsevel, Ya. *Mongol khelnii tovch tailbar toli. Concise Explanatory Dictionary of the Mongolian Language*. Ulaanbaatar: State Publishing Committee.]